



GENCO TOUR  
BUREAU JSC



2018

ЖЕНКО ТУР БЮРО  
ХУВЬЦААТ КОМПАНИ  
ЖИЛИЙН ТАЙЛАН



# КОМПАНИЙН ТАНИЛЦУУЛГА

# 01

## 05-13

- 1.1. Компанийн танилцуулга
- 1.2. Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- 1.3. Засаглал
- 1.4. Амжилтууд

# БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

# 02

## 15-17

- 2.1. Аялал жуулчлалын салбарын мэдээлэл
- 2.2. Бүтээгдэхүүн үйлчилгээ

# 2018 ОНЫ ТАЙЛАН

# 03

## 19-31

- 3.1. Санхүүгийн тайлан  
2019 оны төлөвлөгөө
- 3.2. Үйл ажиллагааны тайлан  
2019 оны төлөвлөгөө
- 3.3. Аудитын дүгнэлт



КОМПАНИЙН  
**ТАНИЛЦУУЛГА**

**Компанийн оноосон нэр:**

Женко тур бюро ХК

**Үйл ажиллагааны чиглэл:**

- Дотоод, Гадаад аялал
- Дотоод, Гадаадын шууд нислэг захиалга
- Бүх төрлийн тээврийн билет захиалга
- Зочид буудлын өрөө захиалга
- Гэр жуулчны бааз
- Уламжлалт баяр наадам зохион байгуулах
- Хурал, семинар зохион байгуулах

**Компанийн албан  
ёсны хаяг:**

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал, оффис-4, ЗИП код: 14251

**Утас:** 7012 0202, 9196 1900, 9401 1900

**И-мэйл:** info@genco-tour.mn

**Веб хуудас:** www.genco-tour.mn

**Фэйсбүүк:** Genco.Tour.Bureau

**Компанийн удирдлага:**

ТУЗ-ын дарга **Данзан ДАЯНБИЛГҮҮН**,  
Гүйцэтгэх захирал **Цэнд ЭНХСАЙХАН**

**Үүсгэн байгуулагдсан  
огноо:**

1997 онд үүсгэн байгуулагдсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2006 оны 01 сарын 11-ний өдрийн 05 тоот тогтоолоор Хувьцаат Компани болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан.

**Ажилчдын тоо:**

Үндсэн – **73** , Гэрээт – **20**

**Эрхэм зорилго, уриа:**

Гадаад дотоодын жуулчдын эрэлт хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн чанартай бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэн, олон улсын түвшинд үнэлэгдэх үндэсний тур оператор компани болох.

**Бидний уриа:**

Тухлах газрыг та сонго Туулах замыг бид хөтөлье

# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт “Женко Тур Бюро” ХК - ны хувьцаа эзэмшигчид ээ, Хатагтай, Ноёд оо! Та бүхэн сайхан хаваржиж байна уу?

Хувьцаа эзэмшигч Та бүхэн Аялал жуулчлалын салбарт хөрөнгө оруулалт хийж Монгол улсын Аялал Жуулчлалын салбарт нэн ялангуяа Их эзэн Хааныхаа алдар суу, нэр төр, түүхэн гавьяаг дархлан мөнхлөх их үйлсийг дэмжин нэгдсэн Их хааны үр удам билээ.

Та бүхэн олон жилийн хүч хөдөлмөрөөсөө дээжлэн Хувьцаа эзэмшиж яваа халуун сэтгэл зүтгэлтэй Монголчууд. Бид бүхний эрхэм зорилго зорилтын эхний үе шатны үйл хэрэг биеллээ олж Эзэн Чингис хааны маань сүрлэг хөшөө Дэлхийд тамгалагдан байр сууриа эзэлсэн. Энэхүү хөшөөт цогцолбор нь “Морьтой хүн” хөшөө ангилалын хувьд Дэлхийд нэгдүгээрт орсоньг та бүхэн мэдэж байгаа. Өвөг дээдсийнхээ хөрөг дүр, хүлэг морийг нь дархлан бүтээсэн хамт олон, нэр хүндийн эзэд нь Та бид билээ.

“Женко Тур Бюро” ХК нь Монголчуудын бахархал болсон Чингис Хааны Морьт Хөшөө Цогцолборыг бүтээн босгосоноос хойш 10 гаруй жил болжээ. Тус компани нь аялал жуулчлалын салбарт өөрийн орны түүх соёл ялангуяа Монголчууд бидний бахархал болсон Их хааны түүх болон XIII зууны Монголчуудын ахуй, үйлчилгээний өвөрмөц шийдлээрээ аялал жуулчлалын салбартаа тэргүүлэгчийн тоонд зүй ёсоор багтжээ. Бид өөрийн орны түүх соёлыг бодитоор харуулж буй цорын ганц аялал жуулчлалын хувьцаат компани юм.

Манай хамт олон үүсэн байгуулагдсан цагаасаа хойш дотоод гадаадын үйлчлүүлэгч, харилцагч нарынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх чимхлүүр ажлыг хийсээр ирлээ.


Аялал жуулчлал нь чанартай, урт удаан хугацааны, орон нутагт ээлтэй хөрөнгө оруулалт болдог учраас Эх орныхоо байгаль орчны хамгаалалт болж чаддаг. Аялал жуулчлал нь Эх орныхоо соёл, уламжлалын ондоошлыг дархлан авч үлддэг эх оронч Үйлдвэрлэл юм. Жуулчдын сонирхлыг тухайн орны Түүх, соёл, уламжлалт ахуй, байгалийн үзэсгэлэн, онцлог үзмэр хөшөө дурсгал, соёлын бусад арга хэмжээ татдаг билээ. Эдийн засаг хөгжиж, хөрөнгө оруулагчдын мөнгө дуртай зүйлээ өөрчилж болох энэ цаг үед Бид юугаараа бусдаас ялгаатай байх, юугаа хуучин хэвээр нь хадгалж авч үлдэх вэ? гэдэг амин чухал асуудлын нэгээхэн хэсгийг нь Бид бүхэн бүтээн байгуулж чадсан юм.

Энэхүү их үйл хэргийг эхлэн санаачилсан анхны Эрхэм Та болон хамтран ажиллагсад, бизнесийн түншүүд, хөрөнгө оруулагчдынхаа итгэлийг алдахгүй урт удаан хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэх зарчмаар улс орныхоо хөгжил дэвшилд хувь нэмрээ оруулахын төлөө манай хамт олон санаа зорилго нэгтэй ажиллаж байна.

Та бидний хамтын сэтгэл зүтгэл, улс Монголын маань хөгжил ирээдүйн замыг гэрэлтүүлнэ гэдэгт итгэлтэй байна.

“Женко Тур Бюро” ХК-ийн  
гүйцэтгэх захирал:  
**Ц.ЭНХСАЙХАН**

## “ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



## НИЙТ АЖИЛТАН 93

ҮНДСЭН АЖИЛТАН 73



ГЭРЭЭТ АЖИЛТАН 20

ОФФИС 21



ОФФИС 4

ЧИНГИС ХААНЫ МОРЬТ  
ХӨШӨӨ ЦОГЦОЛБОР 25



ЧИНГИС ХААНЫ МОРЬТ  
ХӨШӨӨ ЦОГЦОЛБОР 7

13-Р ЗУУН ЦОГЦОЛБОР 27



13-Р ЗУУН ЦОГЦОЛБОР 9



# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

## 5 ХУВИАС ДЭЭШ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

Энэхүү мэдээллийг “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК-аас 2018 оны 12 сарын 31-ны байдлаар авсан тархалтын судалгаанаас бэлтгэв.

Овог нэр	Хувьцааны тоо
“БиДиСЕК ҮЦК” ХК	32.0%
“Баянгол” ХК	13.4%
Х.Баттулга	8.5%
Д.Даваасүрэн	8.6%

**НИЙТ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: 51858**



# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## ЕРДИЙН ГИШҮҮД



Данзан  
**ДАЯНБИЛГҮҮН**

- ТУЗ-н дарга Ердийн гишүүн
- "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Гүйцэтгэх захирал



Бүрэнмэнд  
**ЛХАГВАДОРЖ**

- ТУЗ-н Ердийн гишүүн
- "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Тэргүүн дэд захирал



Нарангэрэл  
**БАТГЭРЭЛ**

- ТУЗ-н Ердийн гишүүн
- "БиДиСЕК ҮЦК" ХК-ийн Дэд захирал



Халтмаа  
**ЦЭНДБАЯР**

- ТУЗ-н Ердийн гишүүн
- "Баянгол Зочид буудал" ХК Гүйцэтгэх захирал



Дашцэрэн  
**ДАВААСҮРЭН**

- ТУЗ-н Ердийн гишүүн
- "Соёолж" ХХК Гүйцэтгэх захирал



Баттулга  
**НАМУУН**

- ТУЗ-н Ердийн гишүүн

## ХАРААТ БУС ГИШҮҮД



Балжинням  
**АМАРСАНАА**

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- "Хэрээг" ХХК Гүйцэтгэх захирал



Тэгшээ  
**ОДНЯМ**

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- Аудитын хороо, цалин урамшууллын хорооны гишүүн
- "Их Од Эдвенчэ" ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Цэнд  
**ЭНХТУЯА**

- ТУЗ-н Хараат бус гишүүн
- Нэр дэвшүүлэх хорооны гишүүн
- "Нүүдэл трейд" ХХК захирал

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН 2018 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүд нь 2018 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар сонгогдсон бөгөөд КТХ болон компанийн дүрмээр олгосон бүрэн эрхийн хүрээнд тасралтгүй үйл ажиллагаа явуулж ирсэн ба өөрийн биеэр болон эчнээ санал хураалтаар нийт 6 хурал зохион байгуулж компанийн улирал бүрийн үйл ажиллагаа, төлөвлөгөөтэй танилцаж холбогдох шийдвэр, зөвлөмжийг өгч ажилласан болно.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн:

ТУЗ-ийн дарга: Д. Даянбилгүүн

ТУЗ-ийн ердийн гишүүд: Б.Лхагвадорж, Н.Батгэрэл, Х.Цэндбаяр, Д.Даваасүрэн, Б.Намуун

ТУЗ-ийн хараат бус гишүүд: Б.Амарсанаа, Т.Одням, Ц.Энхтуяа

ТУЗ-ийн дэргэдэх хороод:

Аудитын хороо: Б.Амарсанаа, Т.Одням, Д.Даваасүрэн

Нэр дэвшүүлэх хороо: Б.Мянганбаяр, Б.Амарсанаа, Ц.Энхтуяа

Цалин урамшууллын хороо: Б.Амарсанаа, Т.Одням, Б.Намуун

Хуралдсан огноо	ГАРСАН ШИЙДВЭР
2018.02.19	Ногдол ашиг хуваарилахгүй тухай шийдвэр гаргав.
2018.03.12	2018 оны төлөвлөгөөг хэлэлцэж батлав. Хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг гаргав.
2018.05.25	ТУЗ-ийн дарга, зөвлөлийн дэргэдэх хороодыг томилов
2018.07.09	Компанийн гүйцэтгэх удирдлагыг өөрчлөн томилж үүрэгт ажлын төлөвлөгөө гарган хэрэгжилтэд хяналт тавин ажиллав. Компанийн үйл ажиллагаа болон санхүүгийн үйл явцад дотоод аудит оруулав.
2018.10.15	Компанийн 3 улирлын үйл ажиллагааг дүгнэж 4-р улирлын үйл ажиллагааны төлөвлөгөөг батлав.
2018.11.22	Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэг гишүүн чөлөөлөгдөх хүсэлтээ өгснөөр нөхөн сонгууль болтол түр гишүүн томилсон. Чингисийн морьт хөшөө цогцолборын үйлчилгээний тарифыг өөрчлөн шинэчлэн батлав. Компанийн үйл ажиллагааны дотоод журмыг шинэчлэн батлав. Албан бичиг хөтлөх журмыг батлав. Аяллын, санхүүгийн үр ашгийг дээшлүүлэх аюулгүй байдлыг хангах үйлчилгээний чанарыг сайжруулах дотоод журмыг батлав. Компанийн бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн батлав. Мэргэжилтнүүдтэй байгуулах хөдөлмөрийн гэрээг шинэчлэн батлав. Мэргэжилтнүүдийн, тогтвор суурьшилтай ажиллуулах, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх зорилгоор үнэлгээ, урамшууллын систем хэрэгжүүлэх журам батлан гаргах хэрэгжилтэд

# АМЖИЛТУУД

- 2006 он** Монголын Хөрөнгийн Биржийн арилжаагаар GTB хувьцаа 1 сая 541 мянган ширхэг борлогдож Монголын Хөрөнгийн Биржийн дээд амжилтыг тогтоов.
- Монголын аялал жуулчлалын холбооны “Оны шилдэг хөрөнгө оруулагч компани”.
- МҮХАҮТ-ийн үнэт цаасны зах зээлийн оны шилдэг компанийн “Меркури” цом.
- МҮХАҮТ-ийн “Үнэт цаасны зах зээлийн оны шилдэг компани “Интерпренёр” шагнал.
- 2007 он** Их Монгол-800 үндэсний хорооны “Шилдэг бүтээн байгуулагч компани”.
- Монголын Хөрөнгийн бирж - Шилдэг хөрөнгө оруулагч, үнэт цаасны зах зээл дээрх хамгийн гүйлгээтэй хувьцаатай компаниар тодорхойлов.
- Монголын Хөрөнгийн Биржийн оны шилдэг үнэт цаас гаргагч компани.
- Монголын аялал жуулчлалын холбооны “Оны шилдэг шинийг санаачлагч” компани.
- Төв аймгийн Эрдэнэ сумын шилдэг хөрөнгө оруулагч компани.
- 2008 он** Монголын барилгын салбарын түүхэнд урьд хожид байгаагүй өвөрмөц архитектурын шийдэл, хэв маягийг агуулсан хөшөө дурсгалын байгууламж болж чадсанаараа “Оны шилдэг барилга” -аар шалгарав.
- МҮХАҮТ - Аялал жуулчлалын салбарын оны шилдэг хөрөнгө оруулагч.
- 2009 он** Монгол Улсын Төвийн бүсийн хөгжлийг дэмжих агентлаг – Алтан гурвалжин цом.
- Монголын Бизнес Хөгжлийн гарц – Монгол чанар цом.
- 2010 он** Монголын 9 гайхамшгийн нэгээр тодров.
- Монголын Хөрөнгийн Биржийн хамгийн амжилттай IPO хийсэн хувьцаат компани.
- 2011 он** Монголын Хөрөнгийн Биржийн хамгийн амжилттай IPO хийсэн хувьцаат компани.
- 2012 он** “Гранд Экспо-2012” - АЯЛАЛ, ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР-ын ГРАН ПРИ
- 2013 он** “ҮНДЭСНИЙ БИЗНЕС ХӨГЖЛИЙН НЭГДЭЛ” - 2013 оны Аялал жуулчлалын салбарын 1160 байгууллагаас шалгарч ПЛАТИНУМ АНГИЛЛЫН НЭГДҮГЭЭР ЗЭРЭГЛЭЛД багтав.
- 2014 он** Guinness World Record – Чингис Хааны Морьт Хөшөө цогцолбор.
- “Монголын бизнес хөгжлийн гарц холбоо” - “МОНГОЛ ЧАНАР” үндэсний брэнд анхдугаар цом.
- Trip Advisor Олон улсын аялал жуулчлалын цахим хуудас – Жуулчдын саналаар Улаанбаатар хотын үзэх ёстой 3 газрын нэгээр нэрлэгдэв.
- 2015 он** МҮХАҮТ-ийн Аялал жуулчлалын салбарын оны онцлох “ENTREPRENEUR 2015” шагнал.
- 2016 он** Монголын аялал жуулчлалын шилдгүүдийг тодруулах “Golden Compass awards” – аас Чингис Хааны Морьт Хөшөө цогцолбор 2016 оны аялал жуулчлалын шилдэг хөрөнгө оруулагчаар тодров.
- 2017 он** БОАЖЯам, АЖХолбооны 2017 оны аялал жуулчлалын салбарын шилдэг хөрөнгө оруулагч.
- 2018 он** МММХ-ийн Grand Expo 2018 – Оны шилдэг тур оператор, шилдэг жуулчны цогцолбор шагнал.






# БИДНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

# АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАР-2017




Монгол Улсад ирсэн жуулчдын тоо




Аялал жуулчлалын салбарын орлого **401 сая ам.доллар**

Дотоодын нийт бүтээгдэхүүнд **804.8 тэрбум төгрөг** буюу **3,1% шууд** оролцоотой






Нийт ажлын байрны **4,9%** буюу **34,000** ажлын байрыг аялал жуулчлалын салбар бүрдүүлж байна



Гадаадын жуулчдын тоо 2016 оны үзүүлэлтээс 71,750-иар өссөн буюу **14%**-ийн өсөлттэй 2017 онд нийт **471,094** жуулчид Монгол улсад аялахаар ирсэн

Тур Оператор      Зочид буудал      Жуулчны бааз

# БҮТЭЭГДЭХҮҮН



- Дотоод, Гадаадын шууд нислэг захиалга
- Бүх төрлийн тээврийн билет захиалга
- Зочид буудлын өрөө захиалга
- Гэр жуулчны бааз
- Уламжлалт баяр наадам зохион байгуулах
- Хурал, семинар зохион байгуулах

Женко тур бюро компани нь дотоодын өндөр зэрэглэлийн 10 гаруй зочид буудал, 20 гаруй ресторан, зоогийн газар, байгалийн үзэсгэлэнт газрууд бүхий 50 гаруй жуулчны бааз, бусад үзвэр үйлчилгээ, соёл амралтын томоохон газруудтай хамтран ажиллаж байна.

Мөн Ази, Европын орнуудтай, тэр дундаа, Япон, Сингапур, Солонгос, Хятад, Орос, Германы аялал жуулчлалын бизнесийн байгууллагуудтай түншлэл, хамтын ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.







## 2018 ОНЫ **ТАЙЛАН**

# 2018 САНХҮҮ ТАЙЛАН

## 2019 САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

ҮЗҮҮЛЭЛТ	2017 он гүйцэтгэл /төгрөгөөр/	2018 он гүйцэтгэл /төгрөгөөр/	2019 он төлөвлөгөө /төгрөгөөр/
Борлуулалтын орлого	3,465,937,193	4,817,876,205	4,024,115,419
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	3,011,613,847	4,147,961,114	3,006,488,788
<b>Нийт ашиг</b>	<b>451,323,346</b>	<b>669,915,091</b>	<b>1,017,626,631</b>
Санхүү ба бусад орлого	890,045	722,079	1,000,000
Үйл ажиллагааны зардал	235,041,564	344,991,304	373,123,305
Бусад зардал	38,023,357	58,181,161	
Бусад олз, гарз	9,805,252	32,608,828	
<b>Татварын өмнөх ашиг</b>	<b>188,953,722</b>	<b>234,855,878</b>	<b>645,503,326</b>
Орлогын татварын зардал	51,337,126	32,620,439	64,550,333
<b>Тайлант жилийн цэвэр ашиг</b>	<b>167,616,596</b>	<b>202,235,439</b>	<b>580,952,993</b>

# 2018 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

## МАРКЕТИНГИЙН АЛБАНЫ ТАЙЛАН

### ДОТООД АЯЛАЛ ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛД

Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд албан ёсны түнш болон зочин хэлбэрээр ажилласан ба “Женко Тур Бюро” ХК энэхүү арга хэмжээнд дотоод аяллын багц бүтээгдэхүүн, гэр баазын үйлчилгээ, Чингисийн хөшөө болон XIII-зуун цогцолбор, галт тэрэг болон онгоцны билет, зочид буудал, тусгай хөтөлбөрт арга хэмжээг сурталчлан нэгдмэл сэтгүүл, брошур, видео шторк бэлтгэн бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан танилцуулсан. Сар болгон тусгай арга хэмжээ болон аяллын багцуудыг хамтран ажилладаг олон улсын аяллын байгууллагуудтай хамтран ажиллаж байна.



### ДОТООД АЯЛАЛ

Дотоодын аялагчдад зориулан гаргадаг аяллууд болон тусгай хөтөлбөрт арга хэмжээнүүдэд зориулан видео реклам (шторк) бэлтгэж Телевиз, FM, сонин, сэтгүүл, Сошиал (facebook, instagram, twitter) сувгуудаар мэдээллүүдийг цаг тухайд нь төлөвлөн хүргэсэн бөгөөд томоохон худалдааны төвүүд болон үйлчилгээний газруудаар биечилсэн сурталчилгаа, хэвлэмэл сэтгүүл брошур тараах үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.



## ЦОГЦОЛБОРУУД

“Чингис хааны морьт хөшөө цогцолбор”, “XIII зуун цогцолбор”-ын борлуулалт нэмэгдүүлэх зорилгоор дотоодын аялал жуулчлалын 4 үзэсгэлэнд оролцсон мөн олон улсын 5 үзэсгэлэнд цогцолборууд болон бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан оролцлоо. Сар болгон борлуулалт маркетинг, тусгай хөтөлбөрт арга хэмжээнүүдийг төлөвлөн зохион байгуулж ажилласан.

### Баримтлан ажилласан маркетингийн үйл ажиллагааны стратеги:

Чанартай үйлчилгээ- “Хямд үнэтэй-шинэ сонголт” стратегийг бүтээгдэхүүн, үйлчилгээн дээр баримтлан ажилласан. Үүнд:

- Жуулчин илгээдэг зах зээл дэх аяллын тур операторуудтай мэдээллийн байнгын эргэх холбоотой хамтран ажилласан.
- Шинэ чиглэлд, янз бүрийн үнийн сонголттой аяллын бүтээгдэхүүн боловсруулах, хэрэглэгчдэд мэдээллийг хүргэхийг зорин ажилласан.
- Аяллын давуу талууд болох зочид буудал, үзвэр үйлчилгээний онцлогийг голлон аялал сонирхож байгаа хүмүүст дэлгэрэнгүй мэдээлэл хүргэсэн.
- Адал явдалт аялал сонирхдог аялагч нарт зориулж бүтээгдэхүүн боловсруулсан.

### Өрсөлдөхүйц үнэ:

- Жуулчин илгээдэг бүх зах зээлд аяллын өрсөлдөхүйц үнийн мэдээллийг түгээн ажиллах тал дээр тогтмол анхаарч ажилладаг.
- Боломжит санхүүгийн чадавхад нь тулгуурласан ачлалын үйлчилгээг аль ч төвшинд бүрдүүлэн ажилласан.
- Байнгын үйлчлүүлэгч нарт зориулсан үнийн хөнгөлөлт, сүүлийн суудлын хөнгөлөлт урамшуулал, гарын бэлэг, ЖТВ бонус карт олгох зэрэг үйлчилгээг санал болгон ажилласан.

### Жуулчин илгээдэг зах зээл дээрх маркетингийн дэмжлэг:

- Гол зах зээлд төлөөлөгч компанитай байнгын эргэх холбоотой ажилласан.
- Тур операторуудтай хамтран зах зээлийн компани ажил зохион байгуулж ажилласан.
- Нэмэлт үзэсгэлэн худалдаа зохион байгуулсан.
- Гадаад түнш компаниудтай хамтран 3 удаагийн шууд нислэгтэй аяллыг амжилттай зохион байгуулсан.



# АЯЛЛЫН АЛБАНЫ ТАЙЛАН

## ГАДААД АЯЛАЛ

Хонг Конг, Тайланд, Хайнан, Дубай, Ханой, Вьетнам, Макао, Сингапур, Манжуур, Мальдив, Жанжажиэ, Бали, Байгаль нуур зэрэг чиглэлд нийт 31 аялал зохион байгуулж 736 жуулчдыг аялуулсан байна. Мөн 2018 онд Женко Тур Бюро ХК-ийн брэнд аялал болсон шууд нислэгтэй Сингапур хотын аялал 200 хүний бүрэлдэхүүнтэй багц аяллыг дахин сэргээн зохион байгуулсан. Энэ жилийн хувьд нийт аялагчдын 60 гаруй хувь нь хувь хүн, гэр бүл байсан бол 40 гаруй хувь нь албан байгууллагын хамт олон байлаа.



## ДОТООД АЯЛАЛ

2018 оны эхний хагаст гадаад улсаас Монгол улсад аялах гадаадын жуулчдыг хүлээн авахтай холбоотой бэлтгэл ажил хийгдсэн. Бэлтгэл ажлын хүрээнд зочид буудал, ресторан, үзвэр, гэр баазуудтай гэрээ хийх, үнийн санал гаргах, хөтөлбөрийг судлан зах зээл бүрийн жуулчдын онцлогт тохируулан шинэчлэн сайжруулах ажлууд хийгдлээ.



# ХҮНИЙ НӨӨЦИЙН АЛБАНЫ ТАЙЛАН

## ХҮНИЙ НӨӨЦИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Компанийн үйл ажиллагааны хэрэгцээнд үндэслэн 2018 оны хүний нөөцийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан. Байгууллагын цаашдын хөгжлийн хэрэгцээнд тулгуурлан хүний нөөцийн бүрдүүлэлтийн цогц төлөвлөгөөг боловсруулсан ба төлөвлөгөөний дагуу бүрдүүлэлтийг хийж байна. Компанийн удирдлага, зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэх үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Хүний нөөцийн төлөвлөлтийн хүрээнд ажил горилогчдын мэдээллийн сан бүрдүүлэх, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулах, шаардлагатай сургалтын хөтөлбөрүүдийг боловсруулах, сургалтыг зохион байгуулах, ажлын гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог боловсруулах, хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагаануудыг төлөвлөн амжилттай хэрэгжүүлж байна.

2018 онд нийт давхардсан тоогоор 46 ажлын байранд бүрдүүлэлт хийснээс нийт 458 ажил горилогч анкетаа илгээсэн байна. Үүнээс 142 хүн ажлын сонгон шалгаруулалт, ярилцлагад орж 41 хүнийг ажлыг байраар ханган тушаал гаргаж, хөдөлмөрийн гэрээ байгуулсан.

Аялал жуулчлалын оргил ачааллын үед ЧХМХ цогцолбор, XIII зуун цогцолбор, оффист нийт 21 гэрээт ажилтан авч ажиллуулсан.



# ЧИНГИС ХААНЫ МОРЬТ ХӨШӨӨ, XIII-Р ЗУУН ЦОГЦОЛБОРЫН ТАЙЛАН

## ЦОГЦОЛБОРУУДЫН ТОХИЖИЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ ТАЛААР

Дотоодын хөрөнгө оруулалтаар бүтээн босголт хийсэн ЧХМХ, 13-р зуун цогцолборууд жил бүр тодорхой тохижилт, зарим тохиолдолд барилга угсралтын ажлууд хийгдэх шаардлага гардаг. Иймээс тус компани нь тухайн жил бүр үйлчилгээний чанар стандартыг барьж ажиллахын тулд 2018 онд мөн тохижилт, техник угсралтын ажлуудыг төлөвлөн дараах үйл ажиллагаануудыг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

### ЧХМХ Цогцолборт

- Өндөр хүчдэлийн цахилгааны урсгал засвар
- Цогцолборын бүрэн хяналтын камержуулалт
- Гэр баазын усан хангамжийн худгийн насосын засвар үйлчилгээ
- эр баазын сантехникийн засвар

### 13-р зуун цогцолборт

- Нарны эрчим хүчний суурилуулалт
- 00 болон душийн сантехникийн угсралт

Дээрх техникийн ажлууд хийгдсэнээр ЧХМХ цогцолборын өндөр хүчдэлийн салбар шугамын техникийн асуудал бүрэн шийдэгдсэн. Хяналтын камерийн угсралтын асуудлыг бүрэн шийдсэн нь үйл ажиллагааны хяналт болон аюулгүй байдлыг эрс сайжруулсан. Гэр баазын усан хангамжийн доголдлыг арилган худгийн насосыг шинээр сольсон нь жуулчдын тав тухтай байдлыг хангахад дорвитой арга хэмжээ боллоо. 13-р зуун цогцолборт хийгдсэн техникийн ажлууд нь мөн жуулчдын тав тухтай байдлыг хангахад чиглэсэн үйл ажиллагаа боллоо.

## ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, БОРЛУУЛАЛТЫГ НЭМЭГДҮҮЛЭХ ТАЛААР

ЧХМХ Цогцолборт хоёр төрлийн музейг байршуулан үйлчилгээний түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна. Үүнд:

- Чингис хааны түүхтэй холбоотой лааны тосон баримлын музей
- Монголчуудын амьдрал уламжлалыг харуулсан угсаатны зүйн музей

Түүнчлэн Монголын уламжлал, ёс заншилтай холбоотой бэлэг дурсгалын хэрэгцээг үндэслэн шинээр түрээслэгчдийг нэмэн цогцолборт жуулчдад зориулсан дэлгүүрүүдийн тоог нэмэн ажиллаж байна.

Борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор уламжлалт эвент арга хэмжээнүүдийг зохион байгууллаа. Үүнд:

- Хүннү Музик Фестивал
- Чингисийн үр сад хүүхдүүдэд зориулсан үйл ажиллагаа
- Наадмын арга хэмжээ /13-р зуун цогцолборт/
- Бид хамтдаа хөтөлбөр

Эдгээр арга хэмжээнүүдийн нь үйлчилгээний чанарыг сайжруулах, үйлчилгээний төрлийг олшруулах, борлуулалтын орлогыг нэмэгдүүлэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн. 13-р зуун цогцолбор нь алслагдсан, цахилгааны бүрэн хангамжгүй байдгаас зарим тохиолдолд төвөөс ирсэн аялагчдад банкны картаар үйлчлүүлэх боломж хязгаарлагдмал байдаг ба энэхүү асуудлыг шийдэхээр тодорхой үйл ажиллагаа төлөвлөн ажиллаж байна.



# САНХҮҮГИЙН ТАЙЛАН

## ХАРААТ БУС АУДИТЫН ДҮГНЭЛТ



### ШИНЭ ИХ ТЭРБУМ АУДИТ ХХК

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,  
1-р хороо, 12-р хороолол, North center, 207 тоот  
Утас: 9919-9075, 8804-3708, И-мэйл: Ikhterbum@gmail.com

2019-03-06 № 19/19  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД  
ТАНАА

### ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

#### Дүгнэлт

Бид “Женко Тур Бюро” ХК-ийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр компанийн санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Аудитын ажлын хүрээнд санхүүгийн тайлангийн дүн болон тодруулгуудын талаар аудитын нотолгоо олж авах горимуудыг гүйцэтгэх ажил багтана.

Сонгон авсан горимууд нь залилан болон алдааны улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдсэнээс үүсэх эрсдлийн үнэлгээ зэргийг багтаасан аудиторын мэргэжлийн үнэлэмжүүдээс хамаарна.

Тэдгээр эрсдлийн үнэлгээнүүдийг хийхдээ аудитор нь байгууллагын дотоод хяналтын үйл явц үр нөлөөтэй эсэх талаар дүгнэлт гаргах зорилгоор биш зөвхөн тухайн нөхцөл байдалд зохистой аудитын горимуудыг зохиох үүднээс байгууллагын санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, тэдгээрийг үнэн зөв толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг харгалзан үзсэн. Мөн аудитын ажилд хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын таарамж, удирдлагын хийсэн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцооллуудын бодитой эсэхийг үнэлэх ажлуудыг багтаасан болно.

Аудитаар санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд, тэдгээрийн нэмэлт тодруулгыг нотлох нотолгоог түүвэр шалгалтын арга ашиглан магадлав.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь гаргасан дүгнэлтэнд хангалттай, зохистой үндэслэл болж чадсан гэдэгт итгэлтэй байна.

## Аудитын гол асуудал

Аудиторын мэргэжлийн үнэлэмжээр “аудитын гол асуудал” гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайланд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц зүйлс болно. Эдгээр асуудлууд нь санхүүгийн тайланг бүхэлд нь хамарсан, аудитын ажлын агуулга болон дүгнэлтийн хэлбэрт тусгалаа олсон тул тусгайлсан санал, дүгнэлт гаргаагүй.

## Тасралтгүй үйл ажиллагааны зарчимтай холбоотой асуудал

Тасралтгүй үйл ажиллагаатай холбоотой материаллаг тодорхой бус байдал бидэнд ажиглагдаагүй.

## Компанийн удирдлагын хүлээх үүрэг, хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэх ба үнэн зөв толилуулах нь удирдлагын үүрэг хариуцлага юм. Энэхүү хариуцлагад нягтлан бодох бүртгэлийн зохистой бодлогуудыг сонгон авч хэрэглэх, мөн нөхцөл байдалд уялдсан нягтлан бодох бүртгэлийн тооцоолуудыг хийх замаар залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх, толилуулах үйл явцад холбоотой дотоод хяналтыг бий болгох, хэрэгжүүлэх, тогтмол хэрэглэж байх хариуцлагууд багтана.

Ийнхүү санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага нь компанийн тасралтгүй үйл ажиллагаа явуулах чадварыг үнэлэх, тодруулга бэлтгэх, компанийг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоох, өөр бусад арга хэмжээ авах зорилгогүй байгаа тохиолдолд нягтлан бодох бүртгэлийн холбоотой асуудлуудыг тодруулга хэлбэрээр бэлтгэх үүрэг хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагыг хүлээнэ.

## Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Хийж гүйцэтгэсэн аудитад үндэслэн эдгээр санхүүгийн тайлангуудын талаар дүгнэлт гаргах нь бидний үүрэг юм.

Бид аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Эдгээр стандартууд нь ёс зүйн шаардлагуудад нийцэж ажиллах, мөн санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй эсэх талаар зохистой нотолгоо олж авахын тулд аудитаа төлөвлөж гүйцэтгэхийг биднээс шаарддаг.

Аудитын ажилд санхүүгийн тайлангийн дүн болон түүний тодруулгуудыг нотлох горимуудыг гүйцэтгэх ажил багтдаг. Аудитын явцад компанид хэрэглэгдэж байгаа нягтлан бодох бүртгэлийн зарчмууд, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой тооцоолол, тайлангууд бодитой эсэхэд дүгнэлт өгсөн болно.



Ц.Мишигдорж - Захирал, МНБ

**“ЖЕНКО ТУР БЮРО” ХК**

**АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

<b>ХӨРӨНГӨ</b>			<b>Төгрөгөөр</b>
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>	<b>Лав</b>	<b>2017.12.31</b>	<b>2018.12.31</b>
Мөнгө, түүнтэй адилтгах зүйлс	4	106,855,609	139,413,380
Дансны ба бусад авлага	5	187,352,882	211,048,391
Татвар, НДШ-ийн авлага	6	8,441,527	4,588,609
Бараа материал	7	332,189,303	200,302,864
Урьдчилж төлсөн тооцоо, зардал	8	224,199,080	255,732,543
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>		<b>859,038,401</b>	<b>811,085,788</b>
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			
Үндсэн хөрөнгө	9	7,276,118,527	8,889,278,098
Биет бус хөрөнгө	10	511,126,430	448,890,627
Биологийн хөрөнгө	11		119,200,000
Хөрөнгө оруулалт ба бусад хөрөнгө	12	1,863,209,627	
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>		<b>9,650,454,584</b>	<b>9,457,368,725</b>
<b>ХӨРӨНГИЙН ДҮН</b>		<b>10,509,492,985</b>	<b>10,268,454,513</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧ</b>			
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Дансны ба бусад өглөг	13	619,009,044	419,963,441
Татвар, НДШ-ийн өглөг	14	336,355,149	414,046,528
Бусад богино хугацаат өглөг	15	502,425,459	687,684,173
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>1,457,789,651</b>	<b>1,521,694,142</b>
<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Урт хугацаат өглөг	16	661,903,132	154,724,730
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>661,903,132</b>	<b>661,903,132</b>
<b>НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>		<b>2,119,692,783</b>	<b>1,676,418,872</b>
<b>ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ</b>			
<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>			
Хувьцаат капитал	17	8,208,560,402	8,208,560,402
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	18	706,061,110	706,061,110
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		(524,821,310)	(322,585,871)
<b>Хувьцаа эзэмшигчдийн өмчийн дүн</b>		<b>8,389,800,202</b>	<b>8,592,035,641</b>
<b>ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН</b>		<b>10,509,492,985</b>	<b>10,268,454,513</b>

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

**“ЖЕНКО ТУР БЮРО” ХК****АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

	Лав	2017.12.31	Төгрөгөөр 2018.12.31
Борлуулалтын орлого	19	3,462,937,193	4,817,876,205
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	20	3,011,613,847	4,147,961,114
<b>Нийт ашиг</b>		<b>451,323,346</b>	<b>669,915,091</b>
Санхүүгийн ба бусад орлого	21	890,045	722,079
Үйл ажиллагааны зардал	22	235,041,564	344,991,304
Бусад зардал	23	38,023,357	58,181,161
Бусад олз, гарз	24	9,805,252	(32,608,828)
<b>Татварын өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>188,953,722</b>	<b>234,855,878</b>
Орлогын татварын зардал	25	21,337,126	32,620,439
<b>Тайлант жилийн цэвэр ашиг (алдагдал)</b>		<b>167,616,596</b>	<b>202,235,439</b>
Бусад дэлгэрэнгүй орлого			
<b>Тайлант жилийн нийт ашиг (алдагдал)</b>		<b>167,616,596</b>	<b>202,235,439</b>
<b>НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ АШИГ (СУУРЬ)</b>		<b>1,676</b>	<b>2,022</b>


Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

**“ЖЕНКО ТУР БЮРО” ХК**

**АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат канитал	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Төгрөгөөр
					Нийт өмчийн дүн
<b>2016 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>7,998,880,200</b>	<b>209,680,202</b>	<b>706,061,110</b>	<b>(692,437,906)</b>	<b>8,222,183,606</b>
Өмчид гарсан өөрчлөлт					
Ногдол ашиг зарласан					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				167,616,596	167,616,596
<b>2017 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>7,998,880,200</b>	<b>209,680,202</b>	<b>706,061,110</b>	<b>(524,821,3101)</b>	<b>8,389,800,202</b>
Өмчид гарсан өөрчлөлт					
Ногдол ашиг зарласан					
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				202,235,439	202,235,439
<b>2018 оны 12 дугаар сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>7,998,880,200</b>	<b>209,680,202</b>	<b>706,061,110</b>	<b>(322,585,871)</b>	<b>8,592,035,641</b>



**“ЖЕНКО ТУР БЮРО” ХК**

**АУДИТЛАСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон тайлант жил

ҮЗҮҮЛЭЛТ	2017.12.31	Төгрөгөөр 2018.12.31
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>3.545.106.367</b>	<b>5.152.486.100</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	3.545.106.367	5.152.486.100
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>3,070,109,860</b>	<b>4,706,253,737</b>
Ажиллагчдад олгосон мөнгө	386,799,468	421,323,799
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	145,741,000	120,019,752
Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	1,587,388,755	3,492,622,046
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	107,216,200	117,681,612
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	32,070,137	36,175,177
Даатгалын төлбөрт төлсөн мөнгө		
Төлсөн хүү	192,520,325	136,147,270
Төлсөн татвар	186,749,556	165,256,238
Бусад мөнгөн зарлага	431,624,419	217,027,843
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>474,996,507</b>	<b>446,232,363</b>
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>890,045</b>	<b>298.754</b>
Хүлээн авсан хүүний орлого	890,045	298.754
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>28.108.900</b>	<b>35,756,638</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	28.108.900	28,100,500
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		7,656,138
<b>Хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(27,218,855)</b>	<b>(35,457,884)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>354.052.691</b>	<b>383.176.883</b>
Зээл үнэт цаасны төлбөрт	354.052.691	383.176.883
<b>Санхүүгийн цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(354,052,691)</b>	<b>(383,176,883)</b>
<b>Валютын ханшийн зөрүү</b>	<b>2,393,642</b>	<b>4,960,176</b>
<b>БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>96,118,603</b>	<b>32,557,772</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,737,005	106,855,609
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	106,855,609	139,413,381

Хавсралт тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.



📍 Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал,  
Оффис-4, Зип код: 14251

☎ 7012 0202, 9460 1900

✉ [info@genco-tour.mn](mailto:info@genco-tour.mn)



GENCO TOUR  
BUREAU JSC



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН МАТЕРИАЛ

2019.04.29





# АГУУЛГА

- 1 Хурлын зар
- 2 Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтыг жагсаалт
- 3 Хурлын дэг
- 4 Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тогтоол
- 5 Хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбоотой материал
  - a Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2018 оны ажлын тайлан
  - b Компанийн 2018 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлт
  - c Компанийн нэрийг өөрчлөх
  - d Компанийн дүрэмд орох өөрчлөлтийн төсөл
  - e Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэр дэвшигчдийн танилцуулга
  - f Ногдол ашиг тараахгүй тухай тогтоол
- 6 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төсөл
- 7 Саналын хуудасны загвар

# 1 ХУРЛЫН ЗАР

## “ЖЕНКО ТУР БЮРО” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-5, Баянгол зочид буудал, оффис-4-т байрлах “Женко тур бюро” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2019 оны 04 сарын 29-ний өдөр 10 цагт болно.

